


БАТЛАВ:
ОЮУТНЫГ ХӨГЖИЛ ЭРХЭЛСЭН
ПРОРЕКТОР Г.ГАЛБАЯР



**МУИС-ИЙН 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ТӨГСӨЛТ
“ЭРДМИЙН БАЯР”-ЫН ЁСЛОЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ
НЭГДСЭН УДИРДАМЖ**

2023-2024 оны хичээлийн жилийн хаврын улирал
“Эрдмийн баяр”-ын ач холбогдол: Монгол Улсын Их Сургууль нь 1942 оны 10 дугаар сарын 05-ны өдөр үүсэн байгуулагдсан. МУИС-ийн Ректорын 1946 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 84 дүгээр тушаалаар анхны төгсөлтөө хийж “Эрдмийн баяр”-аа тэмдэглэж байсан түүхтэй. Энэ жил Монгол Улсын Их Сургууль 79 дэх удаагийн “Эрдмийн баяр”-аа тэмдэглэж байна.

МУИС-ийг төгсөж буй төгсөгчдийн дундаас Монголын ард түмний өмнө хүндтэй гавьяа байгуулсан суутнууд олон төрж гарсан нь МУИС-ийн нэгэн том бахархал билээ. МУИС-ийн “Эрдмийн баяр” нь монголын шинэ үеийн төлөөлөл болсон залуу мэргэжилтэн, дээд боловсролтой иргэнийг нийгэмд бэлтгэж байгаа МУИС-ийн эрдэмтэн багш нар, эрдмийн хамт олон, төгсөгчид, тэдний төрөл төрөгсөд, найз нөхдийн баяр, бахархлын өдөр юм. Энэхүү өдөр нь Төгсөгчдийн хувьд төрөлх сургуулиараа бахархах, үндэсний тэргүүлэх их сургууль МУИС-ийн нэр хүндийг өргөх, эх орны хөгжил дэвшил, бүтээн байгуулалтад өөрийн хувь нэмрээ оруулах, нийгмийн сайн сайхны төлөө мэдлэг боловсролоо зориулах итгэл үнэмшлийг төрүүлдгээрээ чухал ач холбогдолтой юм.

“Эрдмийн баяр”-ын зорилго: МУИС-ийг 2023-2024 оны хичээлийн жилийн хаврын улиралд төгсөж буй нийт суралцагчдад зориулж нэгдсэн ёслол хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулахад оршино.

Хамрах хүрээ: МУИС-ийн эрдмийн хамт олон, эрдэмтэн багш, ажилтан албан хаагчид, их сургуулийн нийт төгсөгчид, гэр бүл, найз нөхөд оролцоно.

- Бакалавр: 2081
- Магистр: 310
- Доктор: 28
- Нийт: 2419

Хэзээ: 2024 оны 06 дугаар сарын 17-ний өдөр 09:00-17:30 цагт

Хаана: “Соёлын төв өргөө”-ний концертын их танхимд

“Эрдмийн баяр”-ын үйл ажиллагааны зохион байгуулалт:

2024 оны 06 сарын 17-ны өдрийн 08:00-17:30 цагт



- Бүх түвшний төгсөгчид эрдмийн баярын ёслолын өмсгөлөө өмссөн байна.
- “Эрдмийн баяр”-ын ёслолын үйл ажиллагааг 3 хэсгээр тусгай цагийн хуваарийн дагуу зохион байгуулна.
- Нийт 2419 төгсөгчөөс орон нутаг дахь салбар сургуулийг төгсөж буй 348 суралцагч тухайн салбар сургуулиас диплом, энгэрийн тэмдгээ гардан авна. 2071 төгсөгч “Соёлын төв өргөө”-нд нэгдсэн ёслолын арга хэмжээнд оролцоно.
- “Эрдмийн баяр”-ын ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаанд оролцох нийт 2071 төгсөгчдөд диплом, энгэрийн тэмдэг гардуулна.
- “Эрдмийн баяр”-ын үйл ажиллагаанд нийт төгсөгчид, МУИС-ийн удирдлагууд, эрдэмтэн багш нар, бүрэлдэхүүн сургуулийн захирлууд дараах хуваарийн дагуу оролцоно.

“Эрдмийн баяр” тэмдэглэх цагийн хуваарь:

№	Үйл ажиллагаа	Хамрагдах төгсөгчийн тоо	Нийт тоо	Цаг	Хэсгийн дугаар
1	Доктор	28	725	2024.06.17 09:00-11:30	I хэсэг
2	Магистр	265			
3	Мэдээллийн технологи, Электроникийн сургууль	272			
4	Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль	160			
5	Инженер, технологийн сургууль	81	714	2024.06.17 12:00-14:30	II хэсэг
6	Хууль зүйн сургууль	186			
7	Бизнесийн сургууль	447			
8	Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбар	167	632	2024.06.17 15:00-17:30	III хэсэг
9	Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбар	234			
10	Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбар	231			
Анхааруулга: Ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаанд оролцож буй нийт төгсөгчид 30 минутын өмнө хүрэлцэн ирж суудлаа эзэлнэ.					

НЭГ: “ЭРДМИЙН БАЯР”-ЫН НЭГДСЭН ЁСЛОЛЫН

АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР:

“Эрдмийн баяр”-ын нэгдсэн ёслолын арга хэмжээний талбайг урьдчилан бэлтгэж, ёслол хүндэтгэлийн үйл ажиллагааг 3 хэсэгт хуваан зохион байгуулна.

2024.06.17-ний өдрийн 09:00-11:30 цагийн арга хэмжээний хөтөлбөр

I хэсэг

- 08:30-09:00 СТӨ зааланд төгсөгчид суудлаа эзлэх
- 09:00-09:03 Нээлт *Хөтлөгч:*
- 09:03-09:05 Төрийн дуулал эгшиглэх
- 09:05-09:10 Баярын мэндчилгээ, МУИС-ийн Ректор профессор Б.Очирхуяг үг хэлэх
- 09:10-09:12 Хөтлөгч төгсөгчдөд зэрэг, цол олгох тушаал уншиж танилцуулна.
Диплом, энгэрийн тэмдэг гардуулах зочдыг урих (*МУИС-ийн Захирал, Зочдын нэрс*)
- 09:12-11:12 Диплом гардуулах үйл ажиллагаа (*Төгсөгчдийн нэрсийг дуудаж, диплом, энгэрийн тэмдгийг хүндэтгэлтэйгээр гардуулна*)
- Докторын зэрэг хамгаалсан төгсөгчид
 - Магистрын зэрэг хамгаалсан төгсөгчид
 - Мэдээллийн Технологи электроникийн Сургууль
 - Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль
- 11:12-11:17 Урлагийн мэндчилгээ
- 11:17-11:20 Төгсөгчдөд гардуулах захиа даалгаврыг уншиж танилцуулах
- 11:20-11:23 Профессорын мэндчилгээ
- 11:23-11:26 МУИС-ийн шилдэг төгсөгч үг хэлнэ.
- 11:26-11:27 Хаалт (хөтлөгч)
- 11:27-11:30 Төгсөгчид нэгдсэн зохион байгуулалттай дурсгалын зураг татуулах


30 минут завсарлага

“Эрдмийн баяр”-ын 1-р хэсгийн заал танхим чөлөөлөх 2-р хэсгийн бэлтгэл ажил (ромбо диплом бэлтгэх, 2-р хэсгийн төгсөгчид суудлаа эзлэх)

2024.06.17-ний өдрийн 12:00-14:30 цагийн арга хэмжээний хөтөлбөр


II хэсэг

- 11:30-12:00 СТӨ зааланд төгсөгчид суудлаа эзлэх
- 12:00-12:02 Нээлт *Хөтлөгч:*
- 12:02-12:05 Төрийн дуулал эгшиглэх
- 12:05-12:10 Баярын мэндчилгээ, МУИС-ийн Ректор профессор Б.Очирхуяг үг хэлэх
- 12:10-12:12 Хөтлөгч төгсөгчдөд зэрэг, цол олгох тушаал уншиж танилцуулна.
Диплом, энгэрийн тэмдэг гардуулах зочдыг урих (*МУИС-ийн Захирал, Зочдын нэрс*)



12:12-14:12 Диплом гардуулах үйл ажиллагаа (*Төгсөгчдийн нэрсийг дуудаж, диплом, энгэрийн тэмдгийг хүндэтгэлтэйгээр гардуулна*)

- Инженер технологийн сургууль
- Хууль зүйн сургууль
- Бизнесийн сургууль



14:12-14:17 Урлагийн мэндчилгээ

14:17-14:20 Төгсөгчдөд гардуулах захиа даалгаврыг уншиж танилцуулах

14:20-14:23 Профессорын мэндчилгээ

14:23-14:26 МУИС-ийн шилдэг төгсөгч үг хэлнэ

14:26-14:27 Хаалт (хөтлөгч)

14:27-14:30 Төгсөгчид нэгдсэн зохион байгуулалттай дурсгалын зураг татуулах

30 минут завсарлага

“Эрдмийн баяр”-ын 2-р хэсгийн заал танхим чөлөөлөх 3-р ээлжийн бэлтгэл ажил (ромбо диплом бэлтгэх, 3-р хэсгийн төгсөгчид суудлаа эзлэх)

2024.06.17-ний өдрийн 15:00-17:30 цагийн арга хэмжээний хөтөлбөр

III хэсэг

14:30-15:00 СТӨ зааланд төгсөгчид суудлаа эзлэх

15:00-15:02 Нээлт *Хөтлөгч:*

15:02-15:05 Төрийн дуулал эгшиглэх

15:05-15:10 Баярын мэндчилгээ, МУИС-ийн Ректор профессор Б.Очирхуяг үг хэлэх

15:10-15:12 Хөтлөгч төгсөгчдөд зэрэг, цол олгох тушаал уншиж танилцуулна.

Диплом, энгэрийн тэмдэг гардуулах зочдыг урих (МУИС-ийн Захирал, Зочдын нэрс)

15:12-17:12 Диплом гардуулах үйл ажиллагаа (*Төгсөгчдийн нэрсийг дуудаж, диплом, энгэрийн тэмдгийг хүндэтгэлтэйгээр гардуулна*)

- Шинжлэх ухааны сургуулийн Байгалын ухааны салбар
- Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбар
- Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбар

17:12-17:17 Урлагийн мэндчилгээ

17:17-17:20 Төгсөгчдөд гардуулах захиа даалгаврыг уншиж танилцуулах


17:20-17:23 Профессорын мэндчилгээ

17:23-17:26 МУИС-ийн шилдэг төгсөгч үг хэлнэ

17:26-17:27 Хаалт (хөтлөгч)

17:27-17:30 Төгсөгчид нэгдсэн зохион байгуулалттай дурсгалын зураг татуулах

**ХОЁР. “ЭРДМИЙН БАЯР”-ЫН ЁСЛОЛ ХҮНДЭТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ**




Ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаанд оролцох төгсөгчдөд өгөх зөвлөмж:

- ✓ Ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаа 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн өглөөний 08:30 цагаас хуваарийн дагуу зохион байгуулагдана.
- ✓ “Эрдмийн баяр”-ын үйл ажиллагаанд нийт төгсөгчид хавсралтад заасан хуваарийн дагуу 3 хэсэгт хуваагдаж диплом, энгэрийн тэмдэг гардаж авна.
- ✓ Хэсэг тус бүр ёслол хүндэтгэлийн ижил агуулга бүхий хөтөлбөр, нарийвчилсан цагийн хуваарийн дагуу зохион байгуулагдана.
- ✓ Хэсэг тус бүр нь 600 гаруй төгсөгчөөс бүрдэх бөгөөд бүрэлдэхүүн, салбар сургууль, хөтөлбөрийн суралцагчидтай нэг хэсэгт хуваагдана.
- ✓ Ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаа 3 цагийн хугацаанд зохион байгуулагдах бөгөөд дараагийн хэсэг эхлэхээс өмнө 30 минут завсарлана. (Хуваарьт хөтөлбөрийн дагуу)
- ✓ Төгсөгчид хувцас солих, ёслолын арга хэмжээнд оролцох бэлтгэлээ хангах сургууль тус бүрд бэлтгэсэн зориулалт бүхий танхимыг 06:00-18:00 цагийн хооронд нээлттэй байлгах боломжтой (Хавсралт - 2)
- ✓ Төгсөгчид хуваарьт цагаас 30 минутын өмнө ирж, СТӨ-ийн хүлээлгийн хэсэгт бэлэн байна.
- ✓ Хуваарьт цагийн дагуу завсарлагааны 30 минутад багтаж танхимд суудлаа эзэлнэ.
- ✓ Нийт төгсөгчид ёслолын танхимд өөрийн дугаарлалт бүхий суудалд сууна. (Хавсралт-1)
- ✓ Диплом, энгэрийн тэмдэг гардан авахдаа суудлын дарааллаа өөрчлөхгүйгээр өөрийн хуваарьт суудалд сууж гардан авна.
- ✓ Нийт төгсөгчдөд хэсэг тус бүрийн тухайлсан хөтөлбөр, диплом гардаж авах нэрсийн жагсаалтын хамтаар хүргэнэ.
- ✓ Магистрын төгсөгчийн энгэрийн тэмдгийг төгсөлтийн ёслолоос өмнө гардуулсан байх бөгөөд энэхүү ажлыг Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын бодлогын газар хариуцна.
- ✓ Диплом энгэрийн тэмдэг гардуулах үеийн дурсгалын зургийг <https://drive.google.com/> холбоосоор төгсөгчдөд нээлттэй байршуулна.

“Эрдмийн баяр”-ын үйл ажиллагаанд ажиллах багш нарт өгөх зөвлөмж:

- ✓ “Эрдмийн баяр”-ын ерөнхий зохион байгуулалтын удирдамжийг тэнхимийнхээ оюутнуудад тайлбарлан таниулна.
- ✓ Тэнхимийн оюутнуудаа “Эрдмийн баяр”-т өөрийн биеэр оролцох эсэх тухай мэдээллийг авч, ирц бүртгэлийг тодорхой болгож ОХТ-д өгнө.
- ✓ Тэнхимийн оюутнуудаа удирдамжид заасан хуваарийн дагуу цагт нь бүртгэж оруулна.

- ✓ Өөрийн хариуцах хэсэгт үг хэлэх профессор багш, нэр хүндтэй төгсөгчидтэй холбогдож, ёслолын хөтөлбөрийг урьдчилан танилцуулж, үйл ажиллагаанд угтан авч оролцуулна.
- ✓ Бүрэлдэхүүн, салбар сургуулийн төгсөгчдийг өөрийн сургуулийн орчинд дурсгалын зураг авхуулах боломж бүхий зориулалтын талбайг тохиромжтой байршилд засаж тохижуулах ажлыг хариуцан зохион байгуулна.
- ✓ “Эрдмийн баяр”-ын удирдамж, хөтөлбөр, шууд дамжуулах анги танхим, бэлтгэл хангах анги танхим, зураг авхуулах байршил зэргийг нийт төгсөгчдөд сайтар танилцуулах ажлыг зохион байгуулна.



Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын бодлогын газрын хөтөлбөрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн, Бүрэлдэхүүн сургуулийн багш, тэнхимийн туслах ажилтан нарт өгөх зөвлөмж:


- ✓ Тэнхимийн оюутнуудаа “Эрдмийн баяр”-т өөрийн биеэр оролцох эсэх тухай мэдээллийг авч, ирц бүртгэлийг тодорхой болгож ОХТ-д өгнө.
- ✓ 06-р сарын 16-нд бүх төгсөгчдийн дипломыг бэлтгэн бэлэн болгосон байна.
- ✓ СХЧБГ-ийн хөтөлбөрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн, тэнхимийн туслах ажилтан нар төгсөх түвшний бүх төгсөгчдөд олгох энгэрийн тэмдгийн гарын үсгээр баталгаажуулж хүлээлцсэн байна.
- ✓ Хоцорсон, тухайн ээлжид оролцоогүй оюутны дипломыг хүлээн авч эрдмийн баярын дараа хүндэтгэлтэйгээр хүлээлгэн өгнө.

“Эрдмийн баяр”-ын үйл ажиллагаанд оролцогч эрдэмтэн багш, эцэг эхчүүдэд өгөх зөвлөмж:

- ✓ Төгсөгчдийн ар гэрийнхэн бэлтгэсэн зориулалтын талбайд дурсгалын зураг авхуулж болно. (Хавсралт-3)
- ✓ Төгсөгчдийн ар гэрийнхэн (*төгсөгчдийн эцэг, эх, ах дүү хамаатан, найз*) “Соёлын төв өргөө”-нд нэвтрэхгүй бөгөөд ёслолын үйл ажиллагаанд цахимаар оролцохыг анхаарна уу.
- ✓ Төгсөгчдийн ар гэрийнхэнд зориулж зориулалтын талбай, танхимд байршуулсан дэлгэцээр диплом гардуулах ёслолын үйл ажиллагааг шууд дамжуулан үзүүлнэ. (Хавсралт-4)

ИХ ТАНХИМ СУУДЛЫН СХЕМ

ПАРТЕР



Д/д	Сургууль, салбар	Хичээлийн байр	Оюутнуудын бэлтгэл анги	Тайлбар
1	МТЭС	Хичээлийн I байр Хичээлийн II байр	330А 130, 133 230, 236	МТЭС төгсөгчдийн бэлтгэл анги
2	ИТС	Хичээлийн II байр	124, 128, 131, 132	ИТС-ийн төгсөгчдийн бэлтгэл анги
3	УТСОУХНУС	Хичээлийн V байр	202, 302, 305, 309, 407, 409	УТСОУХНУС-ийн төгсөгчдийн бэлтгэл анги
4	ХЗС	Хичээлийн II байр	124, 128, 100, 218, 219	ХЗС-ийн төгсөгчдийн бэлтгэл анги
5	Бизнесийн сургууль	Хичээлийн IV байр	112, 118, 119, 204, 205, 206, 216, 301, 303, 306, 308, 304Б	Бизнесийн сургуулийн төгсөгчдийн бэлтгэл анги
6	ШУС-БУС	Хичээлийн II байр	124, 133, 108, 109	БУС-ын төгсөгчдийн бэлтгэл анги
		Хичээлийн I байр	330А	
7	ШУС-НУС	Хичээлийн II байр	105, 128, 131, 132	НУС-ын төгсөгчдийн бэлтгэл анги
8	ШУС-ХУС	Хичээлийн II байр	105, 128, 135, 218, 219,	ХУС-ын төгсөгчдийн бэлтгэл анги

Зөвлөмж: Төгсөгчид бүрэлдэхүүн салбар сургуулийн харьяа анги танхимд хувцас солих, бэлтгэл хангах зорилгоор ашиглахдаа дээрх хуваарийн дагуу ашиглаж болно.

Ээлж тус бүр “Эрдмийн баяр”-ын ёслолын арга хэмжээнд оролцохоос 2-3 цагийн өмнө хувцас солих, бэлтгэл хангах анги танхимыг ашиглах боломжтой.

Зураг даруулах байршил тохижуулах хэсэг



МУИС-ийн хичээлийн
төв байрны урд
талбайд



СТӨ-ийн урд талбайд



МУИС-ийн Номын
сангийн урд талбайд

Шууд дамжуулалтын цэг

		МУИС-ийн Номын сангийн 202 тоот
		МУИС-ийн Номын сангийн 203 тоот
		МУИС-ийн Номын сангийн 302 тоот
		МУИС-ийн Номын сангийн 303 тоот
		МУИС-ийн хичээлийн төв байрны дугуй заал